



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/188

Булган сум

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч
томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2, 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Д.Баярмагнайгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Бадарчийн Одхүү, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Баатарын Ганзориг нарыг томилсугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21, 28 дугаар зүйлийн 28.2.1, 28.2.2, 28.2.3, 28.2.5, 28.2.6, 28.2.8-д заасан эрхийг эдэлж, үүрэг хүлээж оролцохыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Одхүү, Б.Ганзориг нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

8323010153

ХӨСӨНДХ

ХТ